



МОНГОС УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР

БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



# АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ЭМХЭТГЭЛ



УЛААНБААТАР ХОТ  
2017 он



# АГУУЛГА







• АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	5
• МОНГОЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН ТОЙМ	7
• МОНГОЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ОН ЦАГИЙН ХЭЛХЭЭС	8
• МОНГОЛД ИРСЭН ГАДААДЫН ЖУУЛЧДЫН ТОО ГОЛЛОХ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРНУУДААС ИРСЭН ЖУУЛЧИД ЖУУЛЧДЫН МОНГОЛД ИРЖ БУЙ АЯЛЛЫН ЗОРИЛГО	10
• АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН ОРЛОГО ГАДААДЫН ЖУУЛЧДЫН ТӨЛБӨР ТООЦООНЫ ХЭЛБЭР	12
• АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРААС ДНБ-Д ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРААС АЖЛЫН БАЙРАНД ОРУУЛСАН НӨЛӨӨ	14
• АЯЛАГЧИЙН ЭКСПОРТ БОЛОН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛД ОРУУЛСАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	16
• АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ОРЛОГИЙН ХУВИАРЛАЛТ	18
• ТУР ОПЕРАТОР КОМПАНИУДЫН АНГИЛАЛ АНГИЛЛЫН ГЭРЧИЛГЭЭТЭЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАЙДАЛ	20
• ЖУУЛЧИН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	22
• 21 АЙМГИЙН ЖУУЛЧНЫ БААЗ, ЗОЧИД БУУДАЛ, ДЭН БУУДАЛ, АМРАЛТЫН ГАЗАР, РАШААН СУВИЛЛЫН ТООН МЭДЭЭЛЭЛ	24
• АШИГЛАСАН МАТЕРИАЛ	26







# АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Аялал жуулчлал нь дэлхийн эдийн засгийн хурдацтай өсч байгаа салбаруудын нэг бөгөөд олон саяар хэмжигдэх ажлын байрыг бий болгож, экспорт, хөрөнгө оруулалт, гадаад валютын урсгалыг эрс нэмэгдүүлдэг, нийгэм-эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах хөгжлийн гарц хэмээн дэлхий нийтэд үзэж байна.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганаас “дэлхий нийтийн хүн амын харилцан ойлголцлыг дэмжих, баялаг өв уламжлал, соёл иргэншлийн олон талт байдлыг сурталчлан таниулж, өөр хоорондоо ялгаа бүхий уламжлалт соёлуудыг хадгалж үлдэх, ядуурлыг бууруулах замаар дэлхий дахинд энх тайвныг цогцлоох” нь нэн чухал байгаа тул 2017 оныг “Хөгжлийн төлөөх олон улсын тогтвортой аялал жуулчлалын жил” болгон зарласан.

Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас гаргасан статистик мэдээллээс харахад, аялал жуулчлалын салбар нь дэлхийн нийт бүтээгдэхүүний 10 хувь, худалдаа үйлчилгээний 30 хувь, хөрөнгө оруулалтын 7 хувь, хэрэглээний зардлын 11 хувь, татварын орлогын 5 хувь, экспортын 10 хувийг тус тус эзэлж, ажил эрхэлдэг 11 хүн тутмын 1 нь уг салбарт ажлын байраар хангагдаж буй үзүүлэлттэй байна.

2016 онд дэлхий дахинд 1,2 тэрбум гаруй хүн аялж, аялал жуулчлалын салбарын өсөлт 5 хувьд хүрсэн бөгөөд 2030 он гэхэд дэлхий дахинд аялах жуулчдын тоо 1,8 тэрбумд хүрэх урьдчилсан таамаглалтай байна.

Ази, Номхон далайн бүсэд 2016 онд 209 сая олон улсын жуулчид аялсан нь 2015 онтой харьцуулахад 9 хувиар өссөн бөгөөд мөн цаашид тогтмол өсч, 2030 он гэхэд тус бүс нутгийг зорих жуулчдын тоо 535 саяд хүрэх хандлагатай байна.

“Сайтар төлөвлөгдсөн - Сайн хэрэгжүүлсэн аялал жуулчлал” нь тогтвортой хөгжлийн “нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангах” гэсэн гурван үндсэн зарчмыг хангах боломжтой гэж НҮБ-ын Тогтвортой хөгжлийн чуулганаас дүгнэсэн байна.

Төрийн байгууллагууд бодлого хөтөлбөрөө боловсруулж, хэрэгжүүлэх, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд стратеги төлөвлөлтөө хийх, төрийн бус байгууллагууд үйл ажиллагаагаа чиглүүлэхэд аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдлыг тодорхойлох нь нэн чухал юм.

Иймд Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 2016 он хүртэл аялал жуулчлалын салбарын тоон болон чанарын үзүүлэлтүүд хэрхэн өсөж, ямар түвшинд хүрсэн талаарх статистик мэдээллийг нэгтгэн боловсруулж, “Аялал жуулчлалын статистик мэдээллийн эмхэтгэл”-д тусган боловсрууллаа.







# МОНГОЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН ТОЙМ

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын зөвлөлийн 1954 оны 10 дугаар сарын 2-ны өдрийн 507 дугаар тогтоолоор Худалдааны яамны дэргэд Жуулчдад үйлчлэх товчоог байгуулснаар Монголын орчин цагийн аялал жуулчлалын хөгжлийн эхлэл тавигдаж, улмаар 1990 онд зах зээлийн эдийн засагт шилжсэнээр аялал жуулчлалын салбар хувьчлагдаж, хөгжлийн шинэ үе эхэлжээ.

Өнөөдөр Монгол Улсад жилдээ 400 гаруй мянган гадаадын жуулчин аялж, аялал жуулчлалын салбараас дотоодын эдийн засагт 300 гаруй сая ам.долларыг оруулж байгаа бөгөөд гадагшаа болон дотооддоо аялах монгол иргэдийн тоо жил ирэх тусам өсөн нэмэгдсээр байна.

Уламжлалт нүүдэлчин ахуй, соёл, иргэншил, онгон дагшин байгаль, дэлхийг байлдан дагуулсан Чингис хааны түүхээрээ дэлхийн олон улс орноос ялгарах онцлог бүхий манай орныг Дэлхийн Аялал Жуулчлалын Байгууллагаас аялал жуулчлалын нөөцөөр “Үнэ цэнэтэйд орох газар” хэмээн дүгнэж, жуулчдад аюулгүй, найдвартай орны тоонд оруулан зарласан нь цаашид аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх бүрэн нөөц боломж бийг илтгэж буй хэрэг билээ.

Монголын аялал жуулчлалын салбарын хөгжлийг “Аялал жуулчлалын хөгжлийн эхэн үе, Хөгжлийн орчин үе” хэмээх 2 үе шатанд хувааж болох бөгөөд өнөөдрийг хүртэлх хугацаанд болж өнгөрсөн гол үйл явдлуудыг дараах он цагийн хэлхээсээр тоймлон харуулъя.





# МОНГОЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ОН ЦАГИЙН ХЭЛХЭЭС

## МОНГОЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН ЭХЭН ҮЕ:

1954 он

1954 онд одоогийн Жуулчин компани нь Гадаад Худалдааны Яамны дэргэд “Гадаадын жуулчдад үйлчлэх товчоо” нэртэйгээр байгуулагдаж анчин, жуулчид болон социалист хамтын нөхөрлөлийн орнуудын групп жуулчдад үйлчлэх болжээ. Уг товчоог байгуулж байх үед 60 хүн хүлээн авах хүчин чадалтай “Алтай” зочид буудал болон ресторан, 21 автомашин бүхий бааз бий болж, захиргаа ба үйлчилгээний ажилтнуудыг хамруулан нийт 107 хүний орон тоотой байжээ.

1956 он

1956 оны 7 дугаар сард ЗХУ-ын 15 жуулчинг 9 хоног аялуулахаар хүлээн авсан нь анхны зохион байгуулалттай аялал байв. Мөн оны 10 дугаар сард Прага хотноо болсон “Социалист орнуудын жуулчдын байгууллагын анхдугаар бага хурал”-д Монголын төлөөлөгчид оролцсон төдийгүй 10 орчим оронтой жуулчин хүлээн авах гэрээг байгуулсан байна.

1962 он

1962 онд Тэрэлжид, 1964, 1968 онд Өмнөговь аймагт анхны жуулчны баазуудыг байгуулжээ. Тухайн үеийн аяллын чиглэлд Улаанбаатар хот, Ёлын-Ам, Хонгорын элс, Орхоны цутгалан, Хужирт, Хархорин, Тэрэлж, Сонгино, Сөгнөгөр хэмээх газрууд хамаардаг байв.

1975 он

1975 онд “Залуу аялагчдын товчоо”, “Аялал жуулчлалын товчоо” тус тус байгуулагджээ.

1976 он

1976 онд 3681 анчин, жуулчин хүлээн авсан бол 1989 онд 10291 анчин, жуулчин хүлээн авч үйлчилсэн нь тухайн үеийн хамгийн өндөр үзүүлэлт байжээ.



## МОНГОЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН ОРЧИН ҮЕ:

1989 он

1989 онд манай улс Дэлхийн Аялал Жуулчлалын Байгууллагын гишүүнээр элссэн.

1990 он

1990 онд “Гадаадын жуулчдыг үйлчлэх газар”-ыг бие даасан “Жуулчин” нэгтгэл болгож, 1991 онд Өмч хувьчлалын комиссын шийдвэрээр “Жуулчин” хувьцаат компани болгон өөрчилсөн байна.

1995 он

1995 онд Засгийн газрын тогтоолоор “Монгол Улсад аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар 1995-2005 онд баримтлах үндсэн чиглэл”-ийг баталж, Худалдаа Үйлдвэрийн Яаманд аялал жуулчлалын асуудал хариуцсан төрийн захиргааны нэгжийг бий болгожээ.

1998 он

1998 онд Засгийн газрын 192 дугаар тогтоолоор “Аялал жуулчлалын бодлого зохицуулах Үндэсний Зөвлөл”-ийг байгуулж, дүрмийг баталжээ.

1999 он

1999 онд Засгийн газрын 214 дүгээр тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Аялал жуулчлалын газар”-ыг байгуулж, улмаар 2004 онд татан буулгаж, шинээр байгуулагдсан Зам Тээвэр, Аялал Жуулчлалын Яамны бүтцэд нэгтгэсэн.

1999 онд Монгол Улсад Үндэсний Аялал Жуулчлалыг хөгжүүлэх “Мастер төлөвлөгөө”-г баталсан.

2000 он

2000 онд УИХ-аас “Аялал жуулчлалын хууль”-ийг баталсан.

2003 он

2003 оныг “Монголд зочлох жил” болгон зарласан.

2004 он

2004 оныг “Монголыг нээх жил” болгон зарласан.

2006 он

2006 оныг “Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн жил” болгон зарлаж, монголыг гадаадад сурталчлах, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх таатай орчин бүрдүүлэх, Монгол орны түүх дурсгалын зүйлсийг хамгаалах чиглэлээр бодитой ажлууд хийгдсэн.

2011 он

2011 онд ХБНГУ-ын Берлин хотноо жил бүр зохион байгуулагддаг Ай Ти Би Берлин олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Монгол Улс анх удаа “Соёлын түнш” орноор оролцсон.

2015 он

2015 онд Ай Ти Би Берлин олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Монгол Улс “Албан ёсны түнш” орноор оролцсон.


2015 онд анх удаа Монгол Улсын Засгийн газраас “Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан.

2016 он

2016 онд НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллага, түүний дэргэдэх Торгоны замын аялал жуулчлалын хөтөлбөртэй хамтран Монгол Улсад анх удаа “Нүүдлийн аялал жуулчлал ба хотуудын тогтвортой хөгжил” сэдэвт Торгоны замын олон улсын бага хурлыг Улаанбаатар хотноо зохион байгуулсан.




## МОНГОЛД ИРСЭН ГАДААДЫН ЖУУЛЧДЫН ТОО



## ГОЛЛОХ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРНУУДААС ИРСЭН ЖУУЛЧИД

	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
БНХАУ	211,007	196,832	181,523	195,884	200,010	228,547	178,326	157,561	145,029	131,312
ОХУ	98,759	109,975	107,911	119,644	102,738	83,707	74,468	73,055	70,668	84,065
БНСУ	43,930	43,396	38,272	42,231	43,994	44,360	45,178	45,476	47,213	57,587
ЯПОН	17,238	14,939	11,399	14,140	14,988	17,119	18,178	18,282	19,277	19,985
АНУ	12,223	12,474	11,335	12,844	15,423	15,587	14,701	13,987	14,420	15,859
КАЗАКСТАН	4,882	5,473	5,053	5,757	7,973	10,523	11,422	13,562	14,434	13,370
ХБНГУ	8,250	8,027	6,858	8,095	8,545	8,909	9,499	9,551	8,992	9,709
ФРАНЦ	6,341	6,688	6,702	7,527	7,570	7,553	7,407	7,733	7,989	9,035
ИХ БРИТАНИ	6,717	6,781	5,847	6,209	7,120	6,804	6,391	5,758	6,148	6,161
АВСТРАЛИ	4,502	4,466	3,721	5,443	7,093	7,480	6,765	5,1184	4,804	5,631
БУСАД	37,939	37,266	32,876	38,529	44,876	45,304	45,480	2,761	47,230	51,442

## ЖУУЛЧДЫН МОНГОЛД ИРЖ БУЙ АЯЛЛЫН ЗОРИЛГО











# АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН ОРЛОГО



ГАДААДЫН  
ЖУУЛЧДЫН  
ТӨЛБӨР  
ТООЦООНЫ  
ХЭЛБЭР



\* Монгол банк 2015









## АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРААС ДНБ-Д ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

2015 онд Аялал жуулчлалын салбараас ДНБ-д нийт 1,271.2 тэрбум төгрөгийг дотоодын эдийн засагт оруулсан нь ДНБ-ний 5,3%-г эзэлсэн бол 2016 онд 1,327.7 тэрбум төгрөгийг оруулж ДНБ-ний 5,4%-г бүрдүүлсэн байна.

Цаашид аялал жуулчлалын салбараас ДНБ-д оруулах хэмжээ жилд 6,4%-р өсөж 2026 он гэхэд 2,471.9 тэрбум төгрөг хүрч, ДНБ-ний 5,5%-г эзлэх төлөвтэй байна.

### МОНГОЛ: АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ДНБ-Д ҮЗҮҮЛЭХ НИЙТ НӨЛӨӨ



\* ДАЖК



## АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРААС АЖЛЫН БАЙРАНД ОРУУЛСАН НӨЛӨӨ

2015 онд аялал жуулчлалын салбараас нийт 54,000 мянган ажлын байр бий болгосон нь дотоодын нийт ажлын байрны 4,8%-ийг бүрдүүлжээ.

2016 онд аялал жуулчлалын салбараас бий болгосон нийт ажлын байрны тоо 7,2%-иар өсөж 58,000 хүрсэн нь дотоодын нийт ажлын байрны 4,9%-ийг бүрдүүлж байна.

Цаашид аялал жуулчлалын салбараас бий болгох ажлын байрны тоо ирэх 10 жилд тогтмол өсөх бөгөөд 2026 он гэхэд 79,000 хүрч, дотоодын нийт ажлын байрны 6,2 хувийг бүрдүүлэх төлөвтэй байна.

### МОНГОЛ: АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН АЖЛЫН БАЙРАНД ОРУУЛАХ НИЙТ НӨЛӨӨ




\* ДАЖК







## АЯЛАГЧИЙН ЭКСПОРТ БОЛОН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ





2015 онд Амралт зугаалгын аялын зарцуулалт нь (дотоод болон гадаадын жуулчид) Аялал жуулчлалын ДНБ-д оруулсан шууд хувь нэмрийн 82,4%-ийг бүрдүүлсэн бол бизнес аялал нь 17,65%-ийг бүрдүүлсэн байна.

\* ДАЖК

## АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛД ОРУУЛСАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

2015 онд Аялал жуулчлалын салбарт 1,246.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн бол 2016 онд 7,2%-иар өссөн байна. Ирэх 10 жилд аялал жуулчлалын салбарт хийгдэх хөрөнгө оруулалтын хэмжээ 7.2%-р өсөж, 2025 он гэхэд 2,620.7 тэрбум төгрөгт хүрэх төлөвтэй байна.

Аялал жуулчлалын салбарын үндэсний нийт хөрөнгө оруулалтанд эзлэх хувь хэмжээ нь 2016 онд 22,4% байсан бөгөөд 2025 он гэхэд 24,8% -д хүрэх төлөвтэй байна.



\* ДАЖК

















## ТУР ОПЕРАТОР КОМПАНИУДЫН АНГИЛАЛ



\* Монголын Аялал Жуулчлалын Холбоо 2016

## АНГИЛЛЫН ГЭРЧИЛГЭЭТЭЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАЙДАЛ



Нийт байгууллагын тоо	254
Гадаадын хөрөнгө оруулалттай   гхо	57
Дотоодын хөрөнгө оруулалттай   дхо	197


\* Монголын Аялал Жуулчлалын Холбоо 2016







## ЖУУЛЧИН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ



“МИАТ” ТӨХК Бээжин, Сөүл, Москва, Токио, Хонгконг, Берлин, Франкфурт чиглэлүүдэд, “Аэромонголиа” ХХК Хөх хот, Эрхүү чиглэлүүдэд, “Хүннү Эйр” ХХК Хайлаар, Манжуур, Эрээн, Бугат чиглэлүүдэд тогтмол болон захиалгат нислэгүүдийг үйлдэж байна.

2016 онд Олон улсын зорчигч урсгал 790,459 байсан нь 2015 онтой харьцуулахад 3,2% буюу 24,5 мянган зорчигчоор нэмэгджээ.

Авто тээврийн жуулчин тээвэрлэлт гүйцэтгэх гэрээг 2016 онд 137 аж ахуй нэгж байгууллагуудтай байгуулан, 870 тээврийн хэрэгсэлд Жуулчин наалт /TOUR-IST/, 937 жолоочид жуулчин таних тэмдэг олгогджээ.





\* Эх сурвалж: Зам тээврийн хөгжлийн яам 2016



8 | ЖУУЛЧНЫ БААЗ  
5 | ЗОЧИД БУУДАЛ

Баян-Өлгий

6 | ЖУУЛЧНЫ БААЗ  
4 | ГЭР БУУДАЛ  
3 | АМРАЛТЫН ГАЗАР  
6 | ЗОЧИД БУУДАЛ  
2 | МОТЕЛ ДЭН БУУДАЛ  
2 | РАШААН СУВИЛАЛ

Увс

3 | ЖУУЛЧНЫ БААЗ  
2 | ГЭР БУУДАЛ  
2 | АМРАЛТЫН ГАЗАР  
8 | ЗОЧИД БУУДАЛ  
10 | МОТЕЛ ДЭН БУУДАЛ  
2 | РАШААН СУВИЛАЛ

Ховд

3 | ЖУУЛЧНЫ БААЗ  
2 | ГЭР БУУДАЛ  
2 | АМРАЛТЫН ГАЗАР  
7 | ЗОЧИД БУУДАЛ  
40 | МОТЕЛ ДЭН БУУДАЛ  
3 | РАШААН СУВИЛАЛ

Говь-Алтай

10 | ЖУУЛЧНЫ БААЗ  
10 | ЗОЧИД БУУДАЛ  
5 | МОТЕЛ ДЭН БУУДАЛ  
5 | РАШААН СУВИЛАЛ

Завхан

74 | ЖУУЛЧНЫ БААЗ  
130 | ГЭР БУУДАЛ  
16 | ЗОЧИД БУУДАЛ  
14 | МОТЕЛ ДЭН БУУДАЛ  
17 | РАШААН СУВИЛАЛ

Хөвсгөл

26 | ЖУУЛЧНЫ БААЗ  
29 | ЗОЧИД БУУДАЛ

Архангай

4 | ЖУУЛЧНЫ БААЗ  
3 | АМРАЛТЫН ГАЗАР  
8 | ЗОЧИД БУУДАЛ  
2 | РАШААН СУВИЛАЛ

Баянхонгор

30 | ЖУУЛЧНЫ БААЗ  
31 | ГЭР БУУДАЛ  
6 | АМРАЛТЫН ГАЗАР  
11 | ЗОЧИД БУУДАЛ  
7 | МОТЕЛ ДЭН БУУДАЛ  
4 | РАШААН СУВИЛАЛ

Өвөрхангай

АМРАЛТЫН ГАЗАР  
ЗОЧИД БУУДАЛ  
МОТЕЛ ДЭН БУУДАЛ

17 | ЖУУЛЧНЫ  
83 | АМРАЛТЫН  
3 | ЗОЧИД БУ  
10 | МОТЕЛ ДЭ  
2 | РАШААН С

Булган

25 |  
31 |  
3 |  
59 |  
3 |

Өвнөр







## АШИГЛАСАН МАТЕРИАЛ


1. Хил хамгаалах ерөнхий газар, Улсын хилээр нэвтэрсэн зорчигчдын мэдээ - 2016 он
2. Монгол Банк, Монгол Улсад аялж буй гадаадын жуулчдын түүвэр судалгаа - 2015 он
3. Дэлхийн аялал жуулчлалын консул, Аялал жуулчлалын нийгэм, эдийн засгийн нөлөө тайлан - Монгол Улс 2016 он
4. Монголын аялал жуулчлалын холбоо, тайлан - 2016 он
5. Зам тээврийн хөгжлийн яам, Статистик эмхэтгэл - 2016 он
6. 21 аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын тайлан - 2016 он

Боловсруулсан: С.БАЯСГАЛАН  
И.АРИУНБААТАР  
Х.СОДНОМДЭМБЭРЭЛ









2017  
INTERNATIONAL YEAR  
OF SUSTAINABLE TOURISM  
FOR DEVELOPMENT

**MONGOLIA**  
Nomadic by Nature

Address: Ulaanbaatar 15610, Chingeltei District, United  
Nations street 5/2, Government Building 2

☎ | +976-51267010

🌐 | [www.mongolia.travel](http://www.mongolia.travel)    ✉ | [tourism@mne.gov.mn](mailto:tourism@mne.gov.mn)